

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ АУДИТ

АУДИТЫН КОД: СЭА-2023/12-17-НА-НА

ТАТВАРЫН ӨРИЙГ БАРАГДУУЛСНААР ОРЛОГО ТӨВЛӨРҮҮЛЭХ 1,563.3 САЯ
ТӨГРӨГИЙН НӨӨЦ БОЛОМЖИЙГ ТООЦООГҮЙ БАЙНА

Сүхбаатар сум 2023 он

Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Болор

Утас: 70362442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Аудитор Д.Чулуунцэцэг

Утас: 70363047 Цахим хаяг: chuluuntsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.open.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгт, зургийн товьёг	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	4
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	5
БҮЛЭГ 1. АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ ХУУЛЬ, ЭРХИЙН АКТАД БҮРЭН НИЙЦЭЭГҮЙ БАЙНА	6
1.1. Аймгийн 2024 оны төсвийн төслийг хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан боловсруулаагүй байна	6
1.2. Аймгийн 2024 оны төсвийн төсөл нь Төсвийн тухай хуулийн шаардлагад нийцээгүй байна	6
БҮЛЭГ 2. АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ИЛҮҮ ТООЦСОН БАЙНА	7
2.1. Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 4,102.0 сая төгрөгөөр илүү тооцсон байна	7
2.2. Татварын өрийг хуульд заасан хувь хэмжээгээр барагдуулж 1,563.3 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг тооцоогүй байна	9
БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ ДЭЛГЭРЭНГҮЙ ТООЦОО СУДАЛГААГҮЙГЭЭР БӨӨН ДҮНГЭЭР ТӨСӨВЛӨЖ, БАТЛАГДСАН ОРОН ТООНЫ ХЯЗГААРЫГ НЭМЭГДҮҮЛСЭН ТӨСӨВЛӨСӨН БАЙНА	10
3.1. Төсвийн орлогын саналыг үндэслэлгүйгээр өсгөж өргөн мэдүүлснээс орлого буурах, улмаар төсвийн зардлыг бууруулах нөхцөл, шаардлага үүсээд байна	11
3.2. Аймгийн 2024 оны төсвийн төсөлд батлагдсан орон тооны хязгаарыг нэмэгдүүлж, төсөл, арга хэмжээг зардлын дэлгэрэнгүй тооцоо судалгаагүйгээр төсөвлөсөн байна	12
БҮЛЭГ 4. ХОЛБОГДОХ ХУУЛЬ ЭРХИЙН АКТЫН ШААРДЛАГЫГ ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ОНХО, ОНХС-ИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨСӨВЛӨСӨН БАЙНА	14
4.1. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй болон улсын төсвийн байгууллагын урсгал зардлын шинж чанартай төсөл, арга хэмжээг ОНХО-ын төлөвлөгөөнд тусгасан байна	13
4.2. Иргэдийн санал аваагүй болон ОНХС-ийн чиг үүрэгт үл хамаарах төсөл арга хэмжээг ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төсөвлөсөн байна	16
ХАВСРАЛТУУД	

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, Төрийн сангийн хэлтэс
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
ТҮ	Төрийн үйлчилгээ
УИХ	Улсын Их Хурал
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар

Хүснэгтийн товъёг:

Хүснэгт 1	Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоо	8
Хүснэгт 2	Залруулан тооцсон аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоо	8
Хүснэгт 3	Аймгийн 2024 оны төсвийн орлого	10
Хүснэгт 4	ОНХО-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа	14
Хүснэгт 5	Зураг төсөв, тооцоо судалгаагүй төлөвлөсөн төсөл, арга хэмжээний судалгаа	14
Хүснэгт 6	Улсын төсвийн байгууллагуудыг санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт	15
Хүснэгт 7	ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа	16

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 болон УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/03 дугаар тушаалын дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилго:

Сэлэнгэ аймгийн 2024 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ-д хүргүүлэн, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэв.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- *Орон нутгийн төсвийн төслийг хууль, эрх зүйн актад нийцүүлэн төлөвлөсөн үү?*
- *Орон нутгийн төсвийн орлогын нөөц боломжийг бүрэн ашиглаж төлөвлөсөн үү?*
- *Орон нутгийн төсвийн зарлагыг арвилан хэмнэлт, үр ашигтай байхаар төлөвлөсөн үү?*
- *Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн төлөвлөсөн үү?*

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”, 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” болон бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж, ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлал, түүний дотор Төсвийн тухай хуулийн 5 дугаар

бүлэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг гол шалгуур болголоо.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг Сэлэнгэ аймгийн 2022, 2023 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл (батлагдсан болон урьдчилсан), аймгийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн төсөл, холбогдох танилцуулга мэдээлэл, төсвийн орлого бүрдүүлдэг зарим байгууллагаас ирүүлсэн судалгаа, мэдээллийг хамруулан гүйцэтгэв.

Талуудын хүлээх үүрэг, хариуцлага:

Аймгийн Засаг дарга Сэлэнгэ аймгийн 2024 оны төсвийг танилцуулгын хамт бэлтгэн, Төсвийн тухай хуулийн 8.5.1-д заасан цаглабарын дагуу Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага аймгийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн аймгийн 2024 оны төсвийн төслийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах үүрэг хүлээнэ.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Т.Болор, аудитор Д.Чулуунцэцэг нар 2023 оны 11 дүгээр сарын 20-оос 11 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

УИХ-аас аймгийн татварын орлогыг 20,600.0 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 909.0 сая төгрөгөөр, сумдаас аймагт төвлөрүүлэх орлогыг 4,392.7 сая төгрөгөөр, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 26,529.0 сая төгрөгөөр, улсад төвлөрүүлэх орлогыг 1,363.3 сая төгрөгөөр тооцон төсвийг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг тус бүр 51,067.4 сая төгрөгөөр батлан ирүүлсэн байна.

Аймгийн Засаг дарга нь УИХ-аас батлагдаж ирсэн төсвийн орлого, зарлагыг нийт 10,451.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 61,518.7 сая төгрөгөөр батлуулахаар аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн байна.

БҮЛЭГ 1. АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ ХУУЛЬ, ЭРХИЙН АКТАД БҮРЭН НИЙЦЭЭГҮЙ БАЙНА

1.1 АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙГ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД СУУРИЛАН БОЛОВСРУУЛААГҮЙ БАЙНА

1.1.1 Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, **аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг** Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөртэй нийцүүлэн боловсруулсан байна.

1.1.2 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг болох **орон нутгийн төсөв** нь аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна гэж тусгасан байна.

1.1.3 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 79.2 хувь нь хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй (*тайлангийн 4 дүгээр бүлгийн 4.1.6-г харах*), аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн 788.0 сая төгрөгийн зардлыг холбогдох тооцоо судалгаа, нотлох баримтгүйгээр, урьд оны дүнгээр төлөвлөсөн зэргээс үндэслэн орон нутгийн төсвийг аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан боловсруулаагүй байна гэж дүгнэж байна.

1.2 АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШААРДЛАГАД НИЙЦЭЭГҮЙ БАЙНА

1.2.1 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх”-ээр заасан байна.

1.2.2 Гэтэл аймгийн Засаг дарга 2024 оны төсвийн төслийг 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Төрийн аудитын байгууллагад хүргүүлсэн нь аудитыг хугацаанд нь хийж гүйцэтгэхэд хүндрэл учруулсан болно.

1.2.3 Төсвийн төслийг хууль, журмын дагуу үндэслэлтэй боловсруулсан эсэхийг Төсвийн тухай хуулийг шалгуур болгон тулган баталгаажуулахад дараах байдалтай байна. Үүнд:

- *Орон нутгийн төсвийн төслийн танилцуулгыг бэлтгэж ирүүлээгүй,*
- *Аймгийн төсвөөс сумын төсөвт олгохоор төлөвлөсөн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийн саналыг зөрүүтэй тооцоолсон,*
- *Төсвийн төслийг иж бүрэн бэлтгээгүй, хавсралт, дагалдах тооцоолол, дэмжих баримт хангалтгүй,*

- *Орон нутгийн 2024 оны төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг иргэд, олон нийтэд танилцуулж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн аваагүй байна.*

БҮЛЭГ 2. АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ИЛҮҮ ТООЦСОН БАЙНА

2.1 СУМЫН ТӨСВӨӨС АЙМГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫГ 4,102.0 САЯ ТӨГРӨГӨӨР ИЛҮҮ ТООЦСОН БАЙНА

2.1.1 УИХ-аас аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 20,600.0 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 909.0 сая төгрөгөөр, сумдаас аймагт төвлөрүүлэх орлогыг 4,392.7 сая төгрөгөөр, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 26,529.0 сая төгрөгөөр, улсад төвлөрүүлэх орлогыг 1,363.3 сая төгрөгөөр тооцон төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийт 51,067.4 сая төгрөгөөр батлан ирүүлсэн байна.

2.1.2 УИХ-аас батлагдаж ирсэн аймгийн орлого эх үүсвэрийг нийт 10,451.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 61,518.7 сая төгрөгөөр батлуулахаар аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн байна. Нэмэгдүүлэн төсөвлөсөн төсвийн орлого, эх үүсвэрийг нэр төрлөөр нь харуулбал:

- *Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 2,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 20,000.0 сая төгрөгөөр,*
- *Ус, ашигласны төлбөрийн орлогыг 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,600.0 сая төгрөгөөр,*
- *Татварын бус бусад орлогыг 1,338.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2,247.0 сая төгрөгөөр,*
- *Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 47.0 сая төгрөгөөр,*
- *ОНХС-ийн дансны үлдэгдлээс 1,093.4 сая төгрөгийн эх үүсвэр нэмэгдүүлсэн,*
- *Орон нутгийн орлогын дансны үлдэгдлээс 1,258.5 сая төгрөгийн эх үүсвэр нэмэгдүүлсэн,*
- *Сумдын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 4,561.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хүү торгуулийн орлогын төлөвлөгөөг 250.0 сая төгрөгөөр бууруулан төсөвлөсөн байна.*

2.1.3 2024 оны сумдын суурь орлого, зарлагыг тооцоолж Баянгол сумаас 227.0 сая төгрөг, Ерөө сумаас 2,416.6 сая төгрөг, Мандал сумаас 2,326.0 сая төгрөг, Сайхан сумаас 590.7 сая төгрөг, Сүхбаатар сумаас 2,093.6 сая төгрөг, Хүдэр сумаас 1,300.0 сая төгрөг нийт **8,953.90** сая төгрөгийн (*Сангийн яамны хянасан төсвийг 4,561.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж*) орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр тооцсон байна.

2.1.4 Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2-т “*Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашгаас дээд шатны төсөвт дараах байдлаар төвлөрүүлнэ: 56.2.1: доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас бага болон тэнцүү тохиолдолд үндсэн тэнцлийн ашгийн ... 70 хувийг 2020 оны төсвийн жилээс эхлэн тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ.*” гэж заасан байдаг.

2.1.5 Аудитаар сумдын төсвийн үндсэн тэнцлийн ашгаас аймгийн төсөвт төвлөрүүлэхээр тооцсон дээрх орлогыг давтан тооцоолоход зарим сумдын аймагт төвлөрүүлэх орлогыг Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасан нөхцөл, боломж, хувь хэмжээг хэтрүүлэн тооцсон байна.

Хүснэгт 1. Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоо

(сая төгрөгөөр)

Д/д	Сумын нэр	Үндсэн тэнцлийн ашиг	Аймгийн төсөвт төвлөрүүлбэл зохих дүн, (30 хувь)	Аймгийн төсөвт төвлөрүүлэхээр тооцсон дүн	Илүү тооцсон дүн
1	Баянгол	756.7	227.0	227.0	-
2	Ерөө	5,420.2	1,626.0	2,416.6	790.6
3	Мандал	2,969.4	890.8	2,326.0	1,435.2
4	Сайхан	261.4	78.4	590.7	512.3
5	Сүхбаатар	6,978.7	2,093.6	2,093.6	-
6	Хүдэр	1,601.9	480.6	1,300.0	819.4
	дүн	17,988.3	5,396.4	8,953.9	3,557.5

Эх сурвалж: Аймгийн 2024 оны төсвийн төсөл

2.1.6 Дээрх хүснэгтээс харахад Баянгол, Ерөө, Мандал, Сайхан, Хүдэр зэрэг сумдаас нийт 3,557.5 сая төгрөгийн орлогыг аймгийн төсөвт илүү төвлөрүүлэхээр тооцож төлөвлөсөн нь тухайн сумдын орлогын эх үүсвэр дутагдаж, шаардлагатай төсөл арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

2.1.7 Аймгийн төсвийн орлогод тооцогдсон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогын **1,600.0** сая төгрөгийг сумын төсөвт төвлөрөх орлогоор дахин төлөвлөсөн, сумын төсвийн орлогод төвлөрүүлэхээр тооцсон БНАТ-ийн орлогыг **2,404.2** сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

2.1.8 Дээрх 4.004,2 сая төгрөгийн буруу тооцооллыг залруулснаар сумдын төсвөөс аймагт төвлөрүүлэх орлого **544.5** сая төгрөгөөр буурч байна.

Хүснэгт 2. Залруулан тооцсон аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоо

(сая төгрөгөөр)

Д/д	Сумын нэр	ИТХ-д өргөн мэдүүлсэн		Аудитаар залруулан тооцсон		Тооцооллын алдааны зөрүү	
		Үндсэн тэнцлийн ашиг	Аймгийн төсөвт төвлөрүүлбэл зохих дүн	Үндсэн тэнцлийн ашиг	Аймгийн төсөвт төвлөрүүлбэл зохих дүн	Үндсэн тэнцлийн ашиг	Аймгийн төсөвт төвлөрүүлбэл зохих дүн
1	Баянгол	756.7	227.0	-	-	(756.7)	(227.0)
2	Ерөө	5,420.2	1,626.1	4,708.2	1,412.4	(712.0)	(213.6)
3	Мандал	2,969.4	890.8	2,655.5	796.6	(313.9)	(94.2)
4	Сайхан	261.4	78.4	258.4	77.5	(3.0)	(0.9)

5	Сүхбаатар	6,978.7	2,093.6	6,978.8	2,093.6	-	-
6	Хүдэр	1,601.9	480.6	1,572.3	471.7	(29.6)	(8.9)
	Дүн	17,988.3	5,396.5	16,173.1	4,851.9	(1,815.3)	(544.5)

Эх сурвалж: Аймгийн 2024 оны төсвийн төсөл

2.1.9 Ингэснээр сумдын төсвийн үндсэн тэнцлийн ашгийг илүү тооцсоноор аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт **4,102.0** сая төгрөгөөр илүү тооцож, төлөвлөсөн байна.

2.1.10 Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлд “Татварын алба нь энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр татвар төлөгчийн мэдээллийг бусдад өгөх ... байдлаар задруулахыг хориглоно” гэж заасан тул аудитын явцад татвар төлөгч ААН, байгууллагын төлсөн татвар, татварын ногдуулалт, татварын төрөл тус бүртэй танилцах боломжгүй байна. Үүнээс шалтгаалан аймгийн төсөвт төвлөрөхөөр өргөн мэдүүлсэн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 2,000.0 сая төгрөгийг Төсвийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу тооцож, төлөвлөж буй эсэхийг үнэлэх, дүн шинжилгээ хийх боломжгүй байлаа.

2.1.11 Усны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-д “Энэ хуулийн 28.6-д заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглагчтай гэрээ байгуулан эрхийн бичиг олгож бүртгэх, мэдээллийг сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлэх.” гэж заасан байдаг.

2.1.12 Усны газраас аймгийн аймгийн БОАЖГ-т Бороо Гоулд ХХК-ийн Төв аймгийн Борнуур сумаас олборлож байгаа алтны ордны бүтээгдэхүүнд ашиглах усны МҮ-015285 дугаартай дүгнэлт ирүүлсэн тул аймгийн ус, ашигласны төлбөрийн орлогыг 200.0 сая төгрөгөөр, 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн татварын бус бусад орлогыг 1,541.0 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 47.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөн нь үндэслэлтэй байна.

2.2 ТАТВАРЫН ӨРИЙГ ХУУЛЬД ЗААСАН ХУВЬ ХЭМЖЭЭГЭЭР БАРАГДУУЛЖ 1,563.3 САЯ ТӨГРӨГИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ НӨӨЦ БОЛОМЖИЙГ ТООЦООГҮЙ БАЙНА

2.2.1 Монгол Улсын жил бүрийн Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад “Татвар хураалт орлого бүрдүүлэлтийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоон үзүүлэлт”-ийн зорилтот түвшинг тооцохдоо өмнөх онуудын тайлангаар ногдуулсан татварын өр барагдуулалтыг 70 хувиар, төлөвлөж буй жилийн өмнөх жилийн татварын тайлангийн ногдол, өр барагдуулалтыг 80 хувиар тус тус тогтоож, төсвийн орлогыг төлөвлөсөн байдаг.

2.2.2 Гэтэл аймгийн төсвийн орлогыг дээрх эх үүсвэрээр нэмэгдүүлэх нөөц боломжийг тооцоогүй байна.

2.2.3 Өмнөх оны татварын өрийн үлдэгдэл 6,571.9 сая төгрөгөөр тайлагдсанаас 2023 онд 4,338.6 сая төгрөгийн өрийг барагдуулсан байна. Иймээс 2023 оны татварын өрийн эхний үлдэгдэл 2,233.3 сая төгрөгөөс 70.0 хувийн өрийг барагдуулахаар тооцоход аймгийн төсвийн орлогыг **1,563.3** сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөх нөөц боломж байна.

2.2.4 Нэг талаас сумдын үндсэн тэнцлийн ашгийг буруу тооцсоноос сумдаас аймагт төвлөрүүлэх орлогыг **4,102.0** сая төгрөгөөр илүү тооцсон, нөгөө талаас татварын өрийг барагдуулах **1,563.3** сая төгрөгийн нөөц боломжийг тооцоогүй зэргийг нэгтгэн тооцож үзвэл аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн аймгийн 2024 оны төсвийн орлого 61,518.7 сая төгрөгийг 2,538.7 сая төгрөгөөр бууруулж, 58,980.0 сая төгрөгөөр эцэслэн батлахаар байна. Тооцооллын зөрүүг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3. Аймгийн 2024 оны төсвийн орлого

(сая төгрөгөөр)

№	ОРЛОГО	ИТХ-д өргөн мэдүүлсэн төсвийн орлого	Аудитаар тооцсон төсвийн орлого	Өөрчлөлт
1	2	3	4	5
	ОРОН НУТГИЙН НИЙТ ОРЛОГО	25,047.0	26,610.3	1,563.3
1	ТАТВАРЫН ОРЛОГО	22,800.0	22,800.0	-
1.1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	20,000.0	20,000.0	-
1.3	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	800.0	800.0	-
1.4	Тэмдэгтийн хураамж	400.0	400.0	-
1.5	Ус ашигласны төлбөр	1,600.0	1,600.0	-
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,247.0	3,810.3	1,563.3
2.1	Төсөвт байгууллагын өөрийн орлого	47.0	47.0	-
2.2	Хүү, торгуулийн орлого	500.0	500.0	-
2.3	Бусад орлого	1,700.0	3,263.3	1,563.3
3	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	34,119.7	30,017.7	(4,102.0)
3.1	Улсад төвлөрүүлэх төвлөрүүлэг	-	-	-
3.2	Сумдын төсвөөс төвлөрүүлэх	1,363.3	1,363.3	-
3.3	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	8,954.0	4,851.9	(4,102.0)
3.3	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	26,529.0	26,529.0	-
4	УРЬД ОНЫ ҮЛДЭГДЭЛ	1,258.5	1,258.5	-
5	УРЬД ОНЫ ҮЛДЭГДЭЛ (ОНХСан)	1,093.5	1,093.5	-
	НИЙТ ОРЛОГО	61,518.7	58,980.0	(2,538.7)

Эх сурвалж: Аймгийн 2024 оны төсвийн төсөл

БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ ДЭЛГЭРЭНГҮЙ ТООЦОО СУДАЛГААГҮЙГЭЭР БӨӨН ДҮНГЭЭР ТӨСӨВЛӨЖ, БАТЛАГДСАН ОРОН ТООНЫ ХЯЗГААРЫГ НЭМЭГДҮҮЛСЭН ТӨСӨВЛӨСӨН БАЙНА

3.1 ТӨСВИЙН ОРЛОГЫН САНАЛЫГ ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ӨСГӨЖ ӨРГӨН МЭДҮҮЛСНЭЭС ОРЛОГО БУУРАХ, УЛМААР ТӨСВИЙН ЗАРДЛЫГ БУУРУУЛАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА ҮҮСЭЭД БАЙНА

3.1.1 Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсөл боловсруулах журам”-ын 4.3.2-т заасны дагуу орон нутгийн төсөвт байгууллагуудын 2024 оны төсвийн төслийг хүлээн авч, Сангийн Яамнаас ирүүлсэн удирдамж чиглэлийн дагуу хянаж, төсвийн урсгал зардлыг төлөвлөсөн байна.

3.1.2 УИХ-аас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар орон нутгийн 2024 оны төсвийн суурь зарлагыг 55,746.4 сая төгрөгөөр (*аймаг, сумдын*) баталсан байна.

3.1.3 Үүнээс аймгийн төсвийн суурь зарлагыг 17,684.1 сая төгрөгөөр (*урсгал зардал 12,482.2 сая төгрөг, хөрөнгө оруулалт 5,201.9 сая төгрөг*), аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 6,854.3 сая төгрөгөөр, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 26,529.0 сая төгрөгөөр зэрэг аймгийн нийт зарлагыг 51,067.4 сая төгрөгөөр баталсан байна.

3.1.4 Аймгийн Засаг дарга нь УИХ-аар баталсан аймгийн 2024 оны төсвийн зарлагыг 10,451.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 61,518.7 сая төгрөгөөр төлөвлөн аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн байна. Үүнд:

- *Төсвийн урсгал зардлыг 5,775.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 18,257.6 сая төгрөгөөр,*
- *Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг 1,300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 6,501.9 сая төгрөгөөр,*
- *Сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 3,375.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 10,230.2 сая төгрөгөөр гэх мэт.*

3.1.5 Аймгийн ОНХС-ийн орлогын төлөвлөлтөд урьд оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 1,093.5 сая төгрөгөөр тооцон эх үүсвэрийг нэмэгдүүлэхээр өргөн мэдүүлсэн боловч төсвийн зарлага хэсэгт уг эх үүсвэрийг ОНХС-д бус байгууллагуудын урсгал зардлыг санхүүжүүлэхээр төсөвлөсөн байна.

3.1.6 ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оны эхний мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг оруулан тооцож 10,726.2 сая төгрөгөөр өргөн мэдүүлсэн боловч төсвийн зарлагын саналд ОНХС-ийн хөрөнгө оруулалтыг 9,632.7 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тооцсон, өөрөөр хэлбэл ОНХС-ийн оны эхний үлдэгдлийг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнээс 1,093.5 сая төгрөгөөр дутуу тооцоолсон байна.

3.1.7 Мөн аймгийн төсвийн орлогын саналыг 2,538.7 сая төгрөгөөр хий өсгөж өргөн мэдүүлснээс орлого буурах, улмаар төсвийг алдагдалгүй батлахын тулд энэ хэмжээгээр төсвийн зарлагыг бууруулах нөхцөл, байдал үүсээд байна.

3.1.8 Засаг даргаас өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд УИХ-аас батлагдаж ирсэн суурь урсгал зарлагыг 5,775.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнд:

- *Төрийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дахь хэсэгт “Орон нутагт ажилласны нэмэгдлийг ... 80 хүртэл хувиар нэмж олгох асуудлыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвтөө тусган шийдвэрлэж болно.” гэж заасны дагуу цалин, НДШ-ийн зардлыг 2,429.2 сая төгрөгөөр,*
- *Засаг даргын нөөц хөрөнгийг 559.9 сая төгрөгөөр,*
- *Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлыг 788.0 сая төгрөгөөр,*
- *Засаг даргын ерөнхий дансыг 48.8 сая төгрөгөөр,*
- *Засгийн газрын 2023 оны “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 312 дугаар тогтоолын 5 дахь заалтын дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Худалдан авах ажиллагааны газар байгуулж, урсгал зардлыг 446.9 сая төгрөгөөр,*
- *Биеийн тамир спортын газар, Сүхбаатар, Шаамар МСҮТ-ийн тогтмол зардлыг 473.6 сая төгрөгөөр,*
- *Бусад зардлыг 1,029.0 сая төгрөгөөр гэх мэт.*

3.1.9 Аудитын явцад аймгийн төсвийн байгууллагуудын урсгал зардлыг тулган баталгаажуулах явцад БОАЖГ-ын томиллолт, нормативт зардал, хангамж бараа материалын зардал 74.9 сая төгрөг , ИТХ-ын сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөний тэтгэмжийн 2.7 сая төгрөгийг тус тус аймгийн ИТХ, БОАЖГ-ын цалингийн зардалд төлөвлөсөн байсныг залруулав.

3.2 АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД БАТЛАГДСАН ОРОН ТООНЫ ХЯЗГААРЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЗАРДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТООЦОО СУДАЛГААГҮЙГЭЭР ТӨСӨВЛӨСӨН БАЙНА

3.2.1 Төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах үйл ажиллагааг Монгол улсын тухайн жилийн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль эрхийн актууд, төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамжид нийцүүлэн үр ашиг, үр нөлөө, арвилан хэмнэлттэй байхаар төсөвлөж, төлөвлөхөөр зохицуулагдсан байдаг.

3.2.2 Гэтэл аймгийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн 2024 оны орон нутгийн төсвийн төсөлд төсөл арга хэмжээг зардлын дэлгэрэнгүй тооцоо судалгаагүйгээр бөөн дүнгээр төсөвлөсөн, батлагдсан орон тооны хязгаарыг нэмэгдүүлсэн зэрэг өмнөх онд төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттгүйгээр төлөвлөсөн зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

1. *Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн 788.0 сая төгрөгийн зардлыг төсөл, арга хэмжээгээр салгаж, тооцоо судалгаа хийлгүүгээр урьд оны дүнгээр төсөвлөсөн нь төсвийн хяналт сулрах, хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлийг үүсгэж байна.*
2. *Аймгийн төсвийн 4 байгууллагын орон тоог Сангийн Яамнаас 2024 онд 166 байхаар хянасныг 38-аар нэмэгдүүлж 204 болгон, **1,225.0** сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал нэмэгдэхээр төлөвлөсөн байна. Үүнд:*
 - *Аймгийн ИТХ: Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 376 дугаар тогтоолоор ажлын албаны орон тооны хязгаарыг 10 гэж тогтоосныг Сангийн яам хянасан боловч орон тоог 2-оор нэмэгдүүлж, **45.5** сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал,*
 - *Аймгийн ЗДТГ: Сангийн Яамнаас 2024 онд аймгийн ЗДТГ-ыг 96 орон тоотойгоор хянасан боловч гэрээт ажилтны орон тоог хязгаараас 5-аар (жолооч 2, архив 1, архитектор 1, даргын туслах 1) нэмэгдүүлж **164.0** сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал,*
 - *Аймгийн БОАЖГ: Холбогдох хуулийн дагуу тус газрын бүтцэд зайлшгүй ажиллах байгаль хамгаалагч, улсын байцаагч, албан конторын ТҮ-ний албан хаагч зэрэг орон тооны цалин хөлс, НДШ-ийг аймгийн суурь зарлагад тооцсон төсвийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч суурь зарлагад тусгаагдаж хянагдаагүйгээс тус газрын орон тоог нийт 30-аар нэмэгдүүлж, **994.3** сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал,*
 - *СХДАА: Сангийн яамнаас 7 орон тоотойгоор хянасан боловч хязгаараас 1-ээр нэмэгдүүлж, 8 орон тоотойгоор, **21.2** сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал гэх мэт.*
3. *Аймгийн төсвийн 6 байгууллагын УИХ-аар баталсан суурь урсгал зардлыг **877.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсөвлөсөн байна. Үүнд:*
 - *Аймгийн ИТХ: Хангамж, бараа материалын зардлыг 13.7 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 50.4 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 9.9 сая төгрөгөөр, зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлсийг 44.9 сая төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 23.8 сая төгрөгөөр, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг 141.0 сая төгрөгөөр, хуралдааны зардлыг 50.0 сая төгрөгөөр, түр хамгаалах байрны зардлыг 120.1 сая төгрөгөөр, сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөний тэтгэмжийг 25.1 сая төгрөгөөр зэрэг нийт **478.9** сая төгрөгөөр,*
 - *Аймгийн ЗДТГ: Хангамж, бараа материалын зардлыг 45.1 сая төгрөгөөр, нормативт зардлыг 3.5 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 97.0 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 86.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 11.7 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 82.5 сая төгрөгөөр, мэдээлэл сурталчилгааны зардлыг 12.5 сая төгрөгөөр зэрэг нийт **338.8** сая төгрөгөөр,*
 - *СХДАА: Эд хогшил, урсгал засварын зардлыг 21.9 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 4.1 сая төгрөгөөр зэрэг нийт **26.0** сая төгрөгөөр,*
4. *ХААГ: Гэрээт ажилтны орон тоог 1-ээр нэмэгдүүлж, цалин, НДШ-ийн зардлыг **33.3** сая төгрөгөөр гэх мэт.*

3.2.3 Аймгийн БОАЖГ-аас /аймгийн суурь зарлагад тусгаагдах/ бусад байгууллагуудад шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, чиг үүргийн давхардлыг арилгах арга хэмжээг авч орон тоог бууруулан төлөвлөх замаар төсвийн зарлагыг бууруулах нь зүйтэй юм.

БҮЛЭГ 4. ХОЛБОГДОХ ХУУЛЬ ЭРХИЙН АКТЫН ШААРДЛАГЫГ ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ОНХО, ОНХС-ИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨСӨВЛӨСӨН БАЙНА

4.1 ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ БОЛОН УЛСЫН ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫН ШИНЖ ЧАНАРТАЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ОНХО-ЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАСАН БАЙНА

4.1.1 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2024 оны жагсаалтад өмнөх оноос шилжин ирсэн 533.0 сая төгрөгийн 2024 онд санхүүжих дүнтэй 4, шинээр хэрэгжих 4,075.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 24 зэрэг нийт 4,608.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 28 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. ОНХО-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа

(сая төгрөгөөр)

Ангилал	Шилжих			Шинээр эхлэх			Нийт		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга байгууламж				2	627.1	627.1	2	627.1	627.1
Их засвар	2	580.0	268.0	13	2,480.0	2,327.9	15	3,060.0	2,595.9
Тоног төхөөрөмж				9	1,120.5	1,120.5	9	1,120.5	1,120.5
Зураг төсөв	2	265.0	265.0				2	265.0	265.0
Нийт	4	845.0	533.0	24	4,227.6	4,075.5	28	5,072.6	4,608.5

Эх сурвалж: Аймгийн 2024 оны төсвийн төсөл

4.1.2 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээний жагсаалтад шинээр хэрэгжүүлэх 1,229.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл, арга хэмжээг зураг төсөв, үнийн тооцоо судалгаагүйгээр төсөвлөсөн байна.

4.1.3 Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.”; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:13.3.3: “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.” гэж заасныг тус тус зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. Зураг төсөв, тооцоо судалгаагүй төлөвлөсөн төсөл, арга хэмжээний судалгаа
(сая төгрөгөөр)

Д(д)	Төсөл, арга хэмжээний нэр	Зураг төсөвгүй	Тооцоо судалгаагүй
1	Дахин төлөвлөлтөд орсон барилгын буулгалтын ажил /Сүхбаатар сум/		400.0
2	Иргэний танхимын тоног төхөөрөмж /Аймгийн ЗДТГ/		137.5
3	Морь барианы хашаа /Аймаг/		32.0
4	Сургуулийн засвар /Баруунбүрэн сум/	140.0	
5	ЗДТГ-ын засвар /Баянгол сум/	70.0	
6	Ерөнхий боловсролын сургуулийн засвар /Зүүнбүрэн сум/	450.0	
	Дүн	660.0	569.5

Эх сурвалж: Аймгийн 2024 оны төсвийн төсөл

4.1.4 Улсын төсвийн байгууллагуудад тоног төхөөрөмж худалдан авах, байшин барилгыг засварлах зэрэг 7 төсөл, арга хэмжээнд нийт 935.0 сая төгрөгийг төсөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.6.6-д “*тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх.*” гэж заасныг зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6. Улсын төсвийн байгууллагуудыг санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт
(сая төгрөгөөр)

Д(д)	Төсөл, арга хэмжээний нэр	2024 онд санхүүжих дүн
1	Аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн барилгын ажлын үргэлжлэл	227.1
2	Эталон тоног төхөөрөмж (Аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэс)	90.0
3	Архивын өрөөний засвар (Аймгийн прокурорын газар)	100.0
4	Спортын ордны барилгын засвар (Мандал сум)	300.0
5	Усан бассейны дээвэр засвар (Аймгийн Биеийн тамир спортын газар)	32.9
6	Албан хаагчдын байрны засвар (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба)	40.0
7	Барилгын засвар (Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс)	145.0
	Дүн	935.0

Эх сурвалж: Аймгийн 2024 оны төсвийн төсөл

4.1.5 Мөн тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй дараах төсөл, арга хэмжээг ОНХО-ын жагсаалтад тусгаж төсөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д “*төсвийн хөрөнгө оруулалт*” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, **тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ**” гэж заасныг зөрчсөн байна. Үүнд:

- 250.0 сая төгрөгийн санхүүжилттэй “Цэнхэрийн 18, 19, 20-р байрны дээврийн засвар (Сүхбаатар сум),

- 200.0 сая төгрөгийн санхүүжилттэй “Нийтийн эзэмшлийн байрнуудын засвар” (Сүхбаатар сум) гэх мэт.

4.1.6 Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан нийт 24 төсөл арга хэмжээнээс 3,141.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 19 төсөл, арга хэмжээг аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулалгүйгээр төлөвлөсөн байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-д харуулав)

4.2 ИРГЭДИЙН САНАЛ АВААГҮЙ БОЛОН ОНХС-ИЙН ЧИГ ҮҮРЭГТ ҮЛ ХАМААРАХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ОНХС-ИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨСӨВЛӨСӨН БАЙНА

4.2.1 Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад өмнөх оноос шилжин хэрэгжих 3,291.1 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 13, шинээр хэрэгжих 7,435.1 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 49 зэрэг нийт 10,726.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 62 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7. ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа

Ангилал	Шилжих			Шинэ			Нийт		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга байгууламж	9	4,770.6	2,202.6	18	4,703.3	3,629.8	27	9,473.9	5,832.4
Их засвар	3	1,082.4	939.9	6	1,084.3	1,084.3	9	2,166.7	2,024.2
Тоног төхөөрөмж	1	297.1	148.6	24	2,421.0	2,421.0	25	2,718.1	2,569.6
Баяр наадам				1	300.0	300.0	1	300.0	300.0
Нийт	13	6,150.1	3,291.1	49	8,508.6	7,435.1	62	14,658.7	10,726.2

Эх сурвалж: Аймгийн 2024 оны төсвийн төсөл

4.2.2 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдээс санал авч, эрэмбэлээгүй нийт 3,154.8 сая төгрөгийн санхүүжилттэй 24 төсөл, арга хэмжээг (Дэлгэрэнгүйг Хавсралт 2-т харуулав.) төсөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6¹, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.2² дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4.2.3 Зураг, төсөв болон үнийг судалгааг урьдчилан хийгээгүй нийт 90.0 сая төгрөгийн санхүүжилттэй 2 төсөл, арга хэмжээг төсөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29.4³, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн

¹ ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно: 60.3.6.орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, ...

² ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх.

³ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.3⁴ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Багш хөгжлийн төв (Ерөө, Бугант тосгон) 50.0 сая төгрөг,
- Цахилгааны трансформатор (Сүхбаатар сум, 5-р баг) 40.0 сая төгрөг.

4.2.4 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2.1-4.2.8-д заасан чиг үүрэгт хамаарахгүй “Багийн хөгжлийн төвийн байр худалдан авах (Сүхбаатар сум)” төсөл, арга хэмжээнд 350.0 сая төгрөгийг төсөвлөсөн байна.

4.2.5 ОНХС-ийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулаагүй, төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалт гаргаж, иргэд, олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаагүй, санал авч, эрэмбэлэх ажил хийгдээгүй байгаа нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.1.1⁵, 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.1⁶, 7.4⁷, 7.5⁸ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4.2.6 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад тооцоо судалгаа, төсөв нь хийгдээгүй аймгийн “Баяр наадмын зардал”-д 300.0 сая төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймгийн 2024 оны төсвийн төслийг хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан боловсруулаагүй байна.
- Аймгийн 2024 оны төсвийн төсөл нь Төсвийн тухай хуулийн шаардлагад бүрэн нийцээгүй байна.

⁴ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх.

⁵ Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг боловсруулж, жил бүрийн 3 дугаар улиралд багтаан иргэд, олон нийтийн саналыг авна.

⁶ Аймаг, нийслэлийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгийг байгаль орчин, газрын харилцаа, хөдөө аж ахуй, санхүү, төрийн сангийн асуудал хариуцсан ажилтан, холбогдох хэлтсийн албан тушаалтнууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргаар ахлуулсан 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

⁷ Аймаг, нийслэлийн Засаг дарга ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулна.

⁸ Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна.

- Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 4,102.0 сая төгрөгөөр илүү тооцсон байна.
- Татварын өрийн тодорхой хэсгийг барагдуулснаар орлого төвлөрүүлэх 1,563.3 сая төгрөгийн нөөц боломжийг тооцоогүй байна.
- Төсвийн орлогын саналыг үндэслэлгүйгээр өсгөж өргөн мэдүүлснээс орлого буурах, улмаар төсвийг алдагдалгүй батлахын тулд зарлагыг бууруулах нөхцөл, шаардлага үүсээд байна.
- Орон нутгийн төсвийн төсөлд батлагдсан орон тооны хязгаарыг нэмэгдүүлсэн, төсөл арга хэмжээг зардлын дэлгэрэнгүй тооцоо судалгаагүйгээр бөөн дүнгээр төлөвлөсөн байна.
- Холбогдох хуулийн дагуу аймгийн БОАЖГ-ын бүтцэд зайлшгүй ажиллах байгаль хамгаалагч, улсын байцаагч, албан конторын ТҮ-ний албан хаагч зэрэг орон тооны цалин хөлс, НДШ-ийг аймгийн суурь зарлагад тусгуулан батлуулаагүй байна.
- Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 79.2 хувь нь хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй байна.
- ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төсөвлөсөн зарим төсөл арга хэмжээ нь хууль, эрх зүйн актад нийцэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Б.Нарантуяа-д:

- Төсвийн орлого нэмэгдүүлэх, зарлагыг хэмнэх нөөц боломжийг бүрэн тооцоолсны үндсэн дээр орлого зарлагыг бодитоор төлөвлөж, батлах.
- Төсвийн тухай хуулийн 29, 29¹ дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг хэрэгжүүлэх замаар төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр батлах.

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж-д:

- Аймгийн төсвийн төслийг Төсвийн тухай хууль болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд нийцүүлэн иж бүрэн тооцоо, судалгаа, нотлох баримтад үндэслэн төлөвлөж байх.
- Төсвийн орлого, зарлагын тооцооллыг холбогдох хууль, эрхийн актад нийцүүлэн үнэн зөв хийж, ИТХ-д өргөн мэдүүлэх.
- Засаг Даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлыг тооцоо судалгаанд үндэслэн төсөл, арга хэмжээгээр төсөвлөн, батлуулах арга хэмжээ авах.

- Холбогдох хуулийн дагуу аймгийн БОАЖГ-ын бүтцэд зайлшгүй ажиллах байгаль хамгаалагч, улсын байцаагч, албан конторын ТҮ-ний албан хаагч зэрэг орон тооны цалин хөлс, НДШ-ийг аймгийн суурь зарлагад тусгуулан батлуулах арга хэмжээ авах.
- Төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг ОНХО, ОНХС-ийн төлөвлөгөөнд тусгаж, батлуулах.
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалт гаргаж, иргэд, олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсны үндсэн дээр иргэдийн саналаар баталгаажсан төсөл, арга хэмжээг төсөвлөж байх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

Т.БОЛОР

Д.ЧУЛУУНЦЭЦЭГ



Аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдсан
төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	2024 онд санхүүжих дүн	Хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдсан байдал
1	Хурлын танхимын тоног төхөөрөмж /Аймгийн ЗДТГ/	60.0	Тийм
2	Иргэний танхимын тоног төхөөрөмж /Аймгийн ЗДТГ/	137.6	Тийм
3	Газар уснаа явагч завь /Аймгийн Онцгой байдлын газар/	150.0	Тийм
4	Зуухны насос /Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ/	300.0	Тийм
5	Ариутгах татуургын шугамын засвар шинэчлэлтийн ажил /Ерөө, Бугант тосгон/	287.0	Тийм
6	Аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн барилгын ажлын үргэлжлэл	227.1	
7	Дахин төлөвлөлтөд орсон барилгын буулгалтын ажил /Сүхбаатар сум/	400.0	
8	Аймгийн Мэргэжлийн хяналтын байцаагчдын албан хэрэгцээнд автомашин	200.0	
9	Эталон тоног төхөөрөмж /Аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэс/	90.0	
10	Цэцэрлэгийн тоног төхөөрөмж /Баянгол сум/	76.0	
11	Жижүүрийн шуурхай удирдлагын нэгжийн тоног төхөөрөмж /Аймгийн Цагдаагийн газар/	75.0	
12	Морь барианы хашаа /Аймаг/	32.0	
13	Архивын өрөөний засвар /Аймгийн прокурорын газар/	100.0	
14	Сургуулийн засвар /Баруунбүрэн сум/	140.0	
15	Сургуулийн засвар /Баянгол сум/	80.0	
16	ЗДТГ-ын засвар /Баянгол сум/	70.0	
17	Цэцэрлэгийн засвар /Жавхлант сум/	233.0	
18	Ерөнхий боловсролын сургуулийн засвар /Зүүнбүрэн сум/	450.0	
19	Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн гадна засвар /Мандал сум/	200.0	
20	Спортын ордны барилгын засвар /Мандал сум/	300.0	
21	Усан бассейны дээвэр засвар /Аймгийн Биеийн тамир спортын газар/	32.9	
22	Албан хаагчдын байрны засвар /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба/	40.0	
23	Барилгын засвар /Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс/	145.0	
24	Цэнхэрийн 18, 19, 20-р байрны дээврийн засвар /Сүхбаатар сум/	250.0	
	Нийт дүн	4,075.5	

Аймгийн ОНХС-ийн 2024 онд хөрөнгө оруулалтад иргэдээс санал авалгүйгээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт



/сая төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	2024 онд санхүүжих дүн
1	Гэрэлтүүлэг, камержуулалтын ажил /Жавхлант сум/	100.0
2	Инженерийн шугамын ажил /Орхонтуул, Рашаант тосгон/	300.0
3	Дулааны шугамын өргөтгөл, шинэчлэл /Сант сум/	428.5
4	Зоорь барих /Түшиг сум/	170.0
5	Төрийн албан хаагчдын байрны гадна дулаан, цахилгааны шугам /Түшиг сум/	130.0
6	Эрүүл мэндийн төвийн дулааны шугам /Түшиг сум/	18.0
7	Инженерийн шугам сүлжээний ажил /Хүдэр сум/	250.0
8	Гэрэлтүүлгийн ажил /Цагааннуур сум/	115.0
9	Шинээр худаг, сувагчлал хийх /Аймгийн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК/	18.3
10	Эрүүл мэндийн төвийн автомашин /Баруунбүрэн сум/	70.0
11	Цэцэрлэгийн тогоо /Баруунбүрэн сум/	20.0
12	Лед дэлгэц /Баруунбүрэн сум/	10.0
13	Эрүүл мэндийн төвийн автомашин /Баянгол сум/	150.0
14	Сургуулийн багш хөгжлийн төв /Зүүнбүрэн сум/	80.0
15	Гинжит трактор /Мандал сум, Тохилог хараа ОНӨААТҮГ/	250.0
16	Эхо аппарат /Сайхан сум/	70.0
17	Сургуулийн багш хөгжлийн төв /Орхон сум/	70.0
18	Сургуулийн мэдээлэл зүйн танхимын тоног төхөөрөмж /Сайхан сум/	50.0
19	Соёлын төвийн хөгжим, проектер /Түшиг сум/	20.0
20	Ногоочдын дундын парк /Цагааннуур сум/	265.0
21	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Шаамар, Дулаанхаан тосгон/	50.0
22	Эрүүл мэндийн төвийн автомашин /Цагааннуур сум/	120.0
23	Бохир ус соруулах машин /Сэлэнгэ Цэнгэг ус ОНӨААТҮГ/	100.0
24	Спорт залны засвар /Шаамар сум/	300.0
Нийт дүн		3,154.8